



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН  
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 182/ШЗ2019/05574

Улаанбаатар хот

Талуудын эвлэрлийг баталгаажуулах  
тухай

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч  
Ж.Байгалмаа би,

Өргөдөл гаргагч: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж,  
Ньюсайнд групп ХХК-ийн байранд байрлах, "Лэндмн ББСБ" ХК, /5039754/

Эвлэрэлд уригдсан тал: Чингэлтэй дүүрэг, 11 дүгээр хороо, Нуурын 4 дүгээр  
гудамж, 30 тоотод оршин суух, ХИ77012966 дугаарын регистртэй, Боржигон овогт  
Жадамбаагийн Номин-Эрдэнэ,

344 000 төгрөг гаргуулах тухай маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн  
дэмжлэгтэйгээр байгуулсан 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 97 дугаартай  
эвлэрлийн гэрээг 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Өргөдөл гаргагч "Лэндмн ББСБ" ХК нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид  
гаргасан өргөдөлдөө болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс эвлэрүүлэн зуучлагчид  
гаргасан тайлбартаа:

"Лэндмн ББСБ" ХК-ийн харилцагч Ж.Номин-Эрдэнэ нь аппликейшнээр  
дамжуулан гаргасан хүсэлтйн дагуу 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 500 000  
төгрөгийг зээлийн 44 000 төгрөгийн шимтгэлтэй 30 хоногийн хугацаатай 2018 оны  
03 дугаар сарын 28-ны өдөр бүрэн эргэнм төлөх нөхцөлтэйгээр 500 000 төгрөгийг  
Ж.Номин-Эрдэнийн ХААН банкны 5064112262 тоот дансанд шилжүүлсэн.  
Харилцагч Ж.Номин-Эрдэнэ нь 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдөр үндсэн  
зээлээс 156 000 төгрөг, зээлийн шимтгэлээс 44 000 төгрөг, нийт 200 000 төгрөгийн  
төлөлт хийсэн, одоо үлдэгдэл үндсэн зээл болох 344 000 төгрөгийг харилцагчаас  
гаргуулахаар эвлэрүүлэн зуучлалд хандсан гэжээ.

Эвлэрэлд уригдсан талаас эвлэрүүлэн зуучлагчид гаргасан тайлбартаа:  
Өргөдлийн шаардлага 344 000 төгрөгийг төлөхийг хүлээн зөвшөөрч, 2019 оны 07  
дугаар сарын 20-ны өдрийн дотор төлнө гэжээ.

2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 97 дугаартай талуудын хооронд  
байгуулсан эвлэрлийн гэрээнд:

Эвлэрүүлэн зуучлалын хамтарсан уулзалтын явцад уригдсан тал Ж.Номин-  
Эрдэнэ нь өргөдлийн шаардлага 344 000 төгрөгийг төлөхийг хүлэн зөвшөөрч 2019  
оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор улсын тэмдэгтийн хураамж 5 485  
төгрөгийн хамт "Лэндмн ББСБ" ХК-д бүрэн төлж барагдуулахаар тохирч эвлэрэв.  
Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамж 10 570 төгрөг төлсөн болно.  
Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.-т зааснаар эвлэрлийн  
гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаар тохиролцов гэжээ.

015010

ҮНДЭСЛЭХ нь:

Талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр өргөдөл гаргагч "Лэндмн ББСБ" ХК, тайлбар гаргагч Ж.Номин-Эрдэнэ нар нь харилцан ярилцсаны үндсэн дээр эвлэрч, уригдсан тал Ж.Номин-Эрдэнэ нь өргөдлийн шаардлага 344 000 төгрөгийг төлөхийг хүлээн зөвшөөрч, 2019 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор улсын тэмдэгтийн хураамжийн 50 хувь болох 5 485 төгрөгийн хамт бүрэн төлж барагдуулахаар тохиролцон эвлэрсэн нь хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолыг хөндөөгүй байх тул Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.-т заасны дагуу талуудын эвлэрлийг баталгаажуулах нь зүйтэй гэж шүүх үзэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1.-д заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.-т заасныг баримтлан өргөдөл гаргагч "Лэндмн ББСБ" ХК-ийн өргөдлийн шаардлага болох 344 000 төгрөгийг уригдсан тал Ж.Номин-Эрдэнэ төлөхийг хүлээн зөвшөөрч, 2019 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор улсын тэмдэгтийн хураамжийн 50 хувь болох 5 285 төгрөгийн хамт тус тус төлж барагдуулахаар хүлээн зөвшөөрч талуудын эвлэрснийг баталгаажуулсугай.

2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1., Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7<sup>1</sup> дүгээр зүйлийн 7<sup>1</sup>.1.-д зааснаар өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 10 570 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, Ж.Номин-Эрдэнэ нь 10 570 төгрөгийн тал хувь болох 5 285 төгрөгийг "Лэндмн ББСБ" ХК-д төлөхийг дурдсугай.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74<sup>1</sup> дүгээр зүйлийн 74<sup>1</sup>.8.-т зааснаар энэхүү захирамжийг тайлбар гаргагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгүүлэхийг мэдэгдсүгэй.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74<sup>1</sup> дүгээр зүйлийн 74<sup>1</sup>.9.-т зааснаар маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэсэн тохиолдолд талууд давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүйг дурдсугай.

ШҮҮГЧ



Ж.БАЙГАЛМАА